

**“АЛТАРГАНА 2024” XV ОЛОН УЛСЫН ИХ НААДМЫН ШОУ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ХӨГЖИМ, ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БЭЛТГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 04 сарын 28 ны өдөр

№ 06

Булган

**НЭГ. ЗОРИЛГО**

Буриад угсаатны бүлгийн өв соёл, уламжлал, аж амьдралын хэв маяг, ёс заншлыг сахин хамгаалах, сэргээн хөгжүүлэх, өвлүүлэн уламжлуулах үйл явц мөн “Алтаргана 2024” XV Олон Улсын их наадмын хүрээнд зохион байгуулагдах оройн арга хэмжээнд хэрэглэгдэх хөгжим, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангахад оршино.

**ХОЁР. СЭДЭВ**

“Алтаргана 2024” XV Олон Улсын их наадмын оройн шоу арга хэмжээг хөгжим, техник тоног төхөөрөмжөөр хангах

**ГУРАВ. АЖЛЫН ДАРААЛАЛ**

№	Гүйцэтгэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа
1	Шоу арга хэмжээнд хэрэглэгдэх хөгжим, техник тоног төхөөрөмжийн үнийн судалгаа хийж танилцуулах Үүнд: -Хөгжим, техник тоног төхөөрөмж 1 ком -Чадал-40.000W дугарах, хэмжээ-40 нүүр -Хамтлаг /6-8 хүнтэй/ дуучид хөгжмийн зэмсэгтэй ирж тоглох боломжтой дагалдах хэрэгслүүд бүрэн байх	Соёл урлагийн газар Г.Алдармөнх	2024 оны 05 сарын 01-ний өдөр
2	Хөгжим, техник тоног төхөөрөмж нийлүүлэх байгууллагатай гэрээ байгуулах /нийлүүлэгч байгууллагын танилцуулга, ажиллах бүрэлдэхүүний танилцуулга, нийлүүлэх хөгжим, техник тоног төхөөрөмжийн зураг, үзүүлэлтийг хавсаргах/	Нийгмийн бодлогын хэлтэс М.Батчимэг	2024 оны 05 сарын 15-ны өдөр
3	“Алтаргана 2024” XV Олон Улсын их наадмын шоу арга хэмжээний тайзны скиз зургийг хөгжим, техник тоног төхөөрөмж байршуулсан хэлбэрээр зурах	Шалгарсан гүйцэтгэгч компани	2024 оны 05 сарын 20-ны өдөр
4	Зургийн дагуу хөгжим техник, тоног төхөөрөмжийг байршуулж бэлэн байдлыг хангах	Хөгжимт жүжгийн театр О.Ууганчимэг, Шалгарсан гүйцэтгэгч компани	2024 оны 07 сарын 26-ны өдөр
5	Хөгжим техник, тоног төхөөрөмжийг зургийн дагуу байршуулсан эсэх, дугаралт бусад зүйлсийг шалгаж бэлэн байдалд хяналт тавих	Соёл урлагийн газар Г.Алдармөнх	2024 оны 07 сарын 26-ны өдөр

6	“Алтаргана 2024” XV Олон Улсын их наадмын шоу арга хэмжээний явцад хөгжим, техник тоног төхөөрөмжийн гэмтэл, саатал, аюулгүй байдлыг хангаж ажиллах	Шалгарсан гүйцэтгэгч компани	2024 оны 07 сарын 27-ны өдөр
7	“Алтаргана 2024” XV Олон Улсын их наадмын шоу арга хэмжээний явцад хөгжим, техник тоног төхөөрөмжийн гэмтэл, саатал, аюулгүй байдалд хяналт тавих	Соёл урлагийн газар Г.Алдармөнх	2024 оны 07 сарын 27-ны өдөр

#### **ДӨРӨВ. НИЙЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- Томоохон эвент арга хэмжээнүүдэд ажиллаж байсан туршлагатай байх
- Хөгжим, техник тоног төхөөрөмж нь үзүүлэлт, чанарын шаардлага хангасан байх
- Хөгжим техник, тоног төхөөрөмж хариуцан ажиллах хүмүүс нь тухайн чиглэлээр мэргэшсэн, харилцааны болон ажлын ур чадвар сайтай байх